



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№38 /252/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.02.24

Цаг үе, үйл явдал

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ХАРЬЯА ТӨҮГ-УУДЫН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТАЛЛАА

Өнөөдөр Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр яамны харьяа Төрийн өмчит үйлдвэрийн газруудын бизнес төлөвлөгөөг баталлаа. Уг арга хэмжээнд БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганухяг, ТЗУГ-ын дарга хурандаа С.Ванчинхүү болон Төрийн өмчит үйлдвэрийн газруудын удирдлагууд байлцлаа.

Энэ үеэр Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Төрийн өмчит үйлдвэрийн газруудын одоо хийгдэж буй цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажилтай танилцлаа.

Мөн тэрээр "Засгийн газраас Төрийн өмчит үйлдвэрийн газруудын үр ашгийг дээшлүүлэх талаар онцгой анхаарч байгаа. Бидний хувьд салбарынхаа хөгжил дэвшил, Зэвсэгт хүчний хөгжлийн санд хувь нэмрээ оруулах боломжтой аж ахуйн цөөн нэгжтэй. Тиймээс энэ чиглэлд анхаарч ажиллах ёстой" гэлээ.

Төгсгөлд нь сайд Г.Сайханбаяр ТӨҮГ-уудын удирдлагуудад үйлдвэрлэлийн үр ашгаа нэмэгдүүлэх, "Хандлагаа өөрчилж, хариуцлагаа нэмэгдүүлэх" уриалгыг ажил албандаа хэвшүүлэх, зардлуудаа танаж, хэмнэлтийн нарийвчилсан төлөвлөгөө гаргаж ажиллах талаар үүрэг чиглэл өглөө.



АНУ-ЫН ЭКСПЕРТИЙН БАГИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



БХЯ-ны СБТГ-ын дарга хурандаа Ч.Гандирваа АНУ-ын Батлан хамгаалах аюулгүй байдлын хамтын ажиллагааны агентлагийн Аюулгүй байдлын удирдлагын хүрээлэнгийн шинжээч доктор Кристин Гаяага-гаар ахлуулсан экспертийн бүлгийг хүлээн авч уулзлаа. Талууд Монгол Улсын Зэвсэгт хүчний Тусгай хүчний командлалын чадавхыг бэхжүүлэн, хөгжүүлэх

чиглэлээр бодлогын түвшинд хамтран ажиллах талаар санал солилцлоо. Уулзалтын үеэр хурандаа Ч.Гандирваа Монгол Улсын батлан хамгаалах салбарын хууль тогтоомж, эрх зүйн томоохон өөрчлөлт, ахиц дэвшлийн талаар болон урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг баримт бичгүүдэд Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийн талаар мэдээлэл өгөв. Түүнчлэн Зэвсэгт хүчний Тусгай хүчний командлалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж буй АНУ-ын экспертийн бүлгийн бүрэлдэхүүнд талархлаа илэрхийллээ.



ДЭД САЙД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 353 ДУГААР АНГИД АЖИЛЛАЛАА



Зэвсэгт хүчний 353 дугаар анги 2022 оны 2 дугаар сарын 23-ны өдөр Зэвсэгт хүчний 353 дугаар ангид Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай хүрэлцэн ирж ангийн үйл

ажиллагаатай танилцлаа. Батлан хамгаалахын дэд сайдын хамтаар ЗХЖШ-н нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямба, БХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга хурандаа

Б.Түвшинтөр нар хүрэлцэн ирж тулгамдаж буй зарим асуудлуудыг шийдвэрлэлээ.

Ахмад Б.НАНДИНЦЭЦЭГ

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2,271,205 /69.8%/	2,172,533 /66.8%/	1,020,672 31,0%
		98,529 /3,0%/
НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
8232 +112	67	8046

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 429,782,729

Эдгэрсэн
Нийт: 358,424,150


Нас барсан
Нийт: 5,935,587



СҮҮ, ЦАГААН ИДЭЭГ
ӨДӨР БҮР ХЭРЭГЛЭЭ!

ӨДӨР БҮР 2 АЯГА СҮҮ ЭСВЭЛ ТАРАГ УУВАЛ:
» Эрүүл шүдтэй болно.
» Өндөр болно.

ЗУРХАЙ



2022.02.24 ПҮРЭВ ГАРАГ
/БИЛГИЙН ТООЛЛЫН 23/

**ХАВРЫН ТЭРГҮҮН ХАР БАР
САРЫН ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ
ШАР БИЧ ӨДӨР**

Үс засуулбал:

Эд эдлэл идээ ундаа олдоно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

07.43-18.28

Барилдлага:

Үл тохирох

Шүтэн барилдлага:

Сэрэхүй

Суудал: Ус

Энэ өдөр хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, хараал, жатхыг буцаах, бүжиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, урлан бүтээхэд сайн. Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийхэд муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой.

Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, эдлэл, идээ, ундаа олно.

Цахим шууданд

**МЭРГЭЖЛИЙН ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭН
ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА**

“Монгол цэргийн өдөр”-ийг угтаж Зэвсэгт хүчний 065, 124 дүгээр ангийн тусгай салбаруудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Урлаг, спорт, мэргэжлийн цогцолбор” тэмцээнийг 2 дугаар сарын 19-ний өдөр зохион байгууллаа.

Тэмцээнд Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн тусгай салбараас 30 гаруй цэргийн алба хаагч, Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн тусгай салбараас 13 цэргийн алба хаагч оролцлоо. Спортын 7 төрлөөр өрсөлдсөн тэмцээнд Радиотелеграфчин төрөлд ахлах ахлагч Д.Гэрэлчулуун, Тэргүүний операторчин төрөлд ахлагч Ө.Отгончулуун, Тэргүүний планшетчин төрөлд, ахлагч



Б.Амарбаясгалан, Шагайн харвааны төрөл Д.Амармандах, Ширээний теннис эрэгтэй төрөлд,

ахлагч А.Болдхэт, эмэгтэй төрөлд, ахлагч Б.Эрдэнатуул нар тэргүүн байр эзэллээ.

Мөн Дартсын тэмцээний эрэгтэй төрөлд, ахлагч Ө.Отгончулуун, эмэгтэй төрөлд, ахмад Б.Эрдэнатуул, Цэрэгжилтийн спортын буухиа тэмцээнд ахлах ахлагч Х.Энхтүвшин ахлагчтай баг, Волейболын тэмцээнд Н.Урантогос ахлагчтай баг, Сагсан бөмбөгийн тэмцээнд дэслэгч Н.Бямбадалай ахлагчтай баг тамирчид тус тус бусдыгаа манлайллаа.

Ахмад З.АНХБАЯР



**ТАКТИК, ТУСГАЙ БЭЛТГЭЛИЙН ЯВГАН
МАРШИЙГ ГҮЙЦЭТГЭЛЭЭ**



Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тактик, тусгай бэлтгэлийн 30 км-ийн явган маршийг ангийн офицер, ахлагч нарын гар нийлэмжтэй ажиллагааг хангах, цаг агаар хүндрүүлсэн нөхцөлд байлдааны болон олон талт үүрэг гүйцэтгэх үеийн сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшнийг дээшлүүлэх, мэдлэг, дадлага, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор “Хужирбулан-Гачууртын ам-

Улиастайн ам-Хужирбулан”, гэсэн маршрутаар зохион байгууллаа. Маршийн удирдагчаар захирагчийн нэгдүгээр орлогч штабын дарга дэд хурандаа Д.Энх-Амгалан томилогдож, ангийн бүрэлдэхүүний өглөө 08:30 цагт цугларах байрлалд жагсаан ангийн захирагчийн тушаал, маршийн төлөвлөгөө, маршрутыг танилцуулж, цэргийн алба хаагчдын хүн нэг бүрийн хувийн зэвсэг, хамгаалах хэрэглэл, цүнх аранзанд үзлэг хийж ангийн

байрлалаас хөдөлгөөн үйлдсэн. Тактик, тусгай бэлтгэлийн 30 км-ийн явган маршийн ажиллагаанд ангийн захирагч хурандаа Ш.Цэрэнбат бие бүрэлдэхүүнийг уриалан замын ажиллагаанд идэвхтэй хамрагдаж, зааж зөвлөж байсан нь бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн бэлтгэлийг нэмэгдүүлэхэд маш том хүчин зүйл болж байлаа.

Ахмад З.АНХБАЯР

СУРГАЛТАД ХАМРАГДЛАА

Зэвсэгт хүчний 284 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн “Хүний хөгжлийн менежер” сургалтад хамрагдлаа. Батлан хамгаалахын сайдын санаачилгаар ҮБХИС-ийн Нийгэм хүмүүнлэгийн тэнхимийг түшиглэн явуулж буй “Хүний хөгжлийн менежер”, “Цэргийн сэтгэл зүйч” бэлтгэх сургалтад хамрагдаж буй суралцагч бүрэлдэхүүн ангийн нийт бие бүрэлдэхүүнд “Байгууллагын үнэт зүйл”, “Хувь хүний хөгжил” сэдвээр сургалт семинарыг зохион байгуулсан юм.

Сургалтад хамрагдсан бүрэлдэхүүний сэтгэгдэл маш өндөр байсан бөгөөд мэдээ мэдээллээр оюуны цар хүрээгээ тэлсэн үр өгөөжтэй сургалт байлаа гэдгийг оролцогчид онцолсон юм.



**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 2022 ОНЫ ГАРДАН ТУЛААНЫ
АВАРГУУД ТОДОРЛОО**



(013), гутгаар байрт дэд ахлагч Д.Арлангуя (327), 70 кг-ийн жинд тэргүүн байрт дэд ахлагч Б.Бадамсүрэн (327), дэд байрт сонсогч Х.Отгонзул (029), гутгаар байрт ахлах ахлагч Ц.Отгонгөс (350) нар манлайллаа. 1992 оноос хойш зохион байгуулагдаж байгаа энэхүү уламжлалт тэмцээнд энэ жил анх удаа 60, 70 кг-ийн жинд эмэгтэй цэргийн алба хаагчид анх удаа өрсөлдсөн нь онцлог болж байна.

Эрэгтэй цэргийн алба хаагчдын төрөлд байгууллагын дүнгээр Зэвсэгт хүчний 084, 029, 016 дугаар нэгтгэл эхний байруудад шалгарсан бол эмэгтэй цэргийн алба хаагчдын төрөлд байгууллагын дүнгээр Зэвсэгт хүчний 350 327 029

Эрэгтэйчүүдийн 60 кг-ийн жинд дэслэгч Х.Энх-Амар (029), дэд байрт дэд ахлагч С.Давааням (084), гутгаар байрт дэд ахлагч Г.Сумъяабазар (330), дэслэгч Э.Санжаа (310), 65 кг-ийн жинд тэргүүн байрт сонсогч С.Алдаржав (029), дэд байрт ахлах ахлагч Б.Батжаргал (084), гутгаар байрт ахлагч Н.Хэнзээ (350), сонсогч Ш.Бат-Итгэл (029) нар шалгарлаа. 70 кг жинд тэргүүн байрт ахлагч Г.Бат-Ирээдүй (014), дэд байрт ахлах ахлагч Т.Төрбат (084), гутгаар байрт дэд ахлагч Э.Амарбаяр (119), ахлагч Д.Чулуунбаатар (350), 75 кг-ийн жинд тэргүүн байрыг ахлагч Г.Наранхүү (327), дэд байрт байлдагч Б.Очирхуяг (013), гутгаар байрт ахлагч н.Ариунжигүүр (084), ахлах дэслэгч Д.Алтансүх (016) нар эзлэв.

Түүнчлэн 80 кг-ийн жинд тэргүүн байрт ахлагч Ч.Нямренчин (084), дэд байрт ахлах ахлагч С.Норованжил (089), гутгаар байрт ахлагч Б.Мөнх-Эрдэнэ (084), ахлах ахлагч Т.Баярсайхан (016), 85 кг жинд тэргүүн байрт дэслэгч Б.Наадам (029), дэд байрт ахлагч



Б.Дэмчигдугар (150), гутгаар байрт ахлагч Г.Пүрэв-Очир(330), байлдагч Г.Үүрийнцолмон (032) нар тус тус шалгарлаа. Эмэгтэй цэргийн алба хаагчдын гардан тулааны 60 кг-ийн жинд тэргүүн байрт дэд ахлагч С.Нандин-Эрдэнэ (350), дэд байрт ахлагч Т.Буяннэмэх

дүгээр анги тус тус бусдыгаа хошуучиллаа.

Түүнчлэн эдүгээ Зэвсэгт хүчний 2022 оны аварга шалгаруулах олд таталтын тэмцээн үргэлжлэн явагдаж байна.

Хошууч З.БАТ-ОРГИЛ

**ЗЭВСЭГТ ХҮЧИНД АНХ УДАА “ХАДАН ХАНАНЫ
АВИРАЛТЫН ЗААЛ” БАРИГДАХ ГЭЖ БАЙНА**



Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн “Хадан хананы авиралтын заал”-ыг барих ажлыг ирэх сард эхлүүлэхээр боллоо. Заалны шав тавих ёслолын ажиллагаа энэ сарын 21-ний өдөр болж, ангийн удирдлага, бие бүрэлдэхүүнээс гадна БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын захирал Э.Мөнхнаран, гүйцэтгэгч байгууллага “Оюу Донж Хаус” ХХК-ын захирал Г.Тэмүүлэн нар оролцлоо. “Хадан хананы авиралтын заал”

нь Зэвсэгт хүчинд анх удаа баригдаж байгаагаараа онцлог бөгөөд уулын тусгай батальоны алба хаагчдын үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх, бие бялдрыг хөгжүүлэх, бусад сургалт дадлагад онцгой ач холбогдолтой, бидний хүсэн хүлээсэн өргөө юм.

Соёл хүмүүжлийн офицер дэслэгч Б.ГЭРЭЛТ-ОД

“САЙН ҮЙЛСИЙН АЯН”-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн Эмэгтэйчүүдийн зөвлөлөөс 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Сайн үйлсийн аян”-ыг зохион байгууллаа. Тус аяны хүрээнд ангийн бие бүрэлдэхүүний хүүхдүүдэд дотоод нөөц бололцоогоо ашиглан хичээлийн хэрэгсэл бэлэглэсэн.

Эмэгтэйчүүдийн зөвлөл нь хамт олны дунд эерэг хандлагыг түгээх, хамт олонч байдлыг сайжруулах, ажилчин алба хаагчдын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зорилгын хүрээнд цаашид олон бүтээлч ажил хийхээр төлөвлөөд байна.

